



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/48/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хэрлэн хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204

Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |



| | |
|--|----|
| Аудитын гэрчилгээ | 3 |
| Аудитын тайлан | 5 |
| 2.1. Оршил..... | 5 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 5 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин..... | 6 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 6 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 6 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 7 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 7 |
| 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 8 |
| 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 8 |
| 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал..... | 9 |
| 2.13. Шилэн дансны мэдээлэл..... | 10 |
| 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 10 |
| 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 10 |
| Менежментийн захидал | 11 |
| Аудит хийгдсэн санхүүгийн тайлан | 12 |
| 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан | 12 |
| 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 13 |
| 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 14 |
| 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 15 |
| 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 16 |



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 253

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэрлэн сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520290



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ





2.1. Оршил

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга А.Наранцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 19-нөөс 2020 оны 02 дугаар сарын 21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 3/38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах”-д оршино.

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах
- Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.



2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,137,091.1 мянган төгрөгөөс тооцон 42,741.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 45,541.8 мянган төгрөгөөр тооцсон нь зардлын гүйцэтгэл өмнөх оноос өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 337,533.7 мянган төгрөгөөр буюу 3,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|--------------------|--------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 125,282.2 | 130,991.4 | 5,709.3 |
| Үндсэн хөрөнгө | 10,942,717.0 | 11,939,373.0 | 999,656.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | -1,423,018.9 | -2,087,850.4 | -664,831.5 |
| Нийт хөрөнгө | 9,644,980.3 | 9,982,514.0 | 337,533.7 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 9,644,980.3 | 9,982,514.0 | 337,533.7 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 9,644,098.3 | 9,982,514.0 | 337,533.7 |

Авлага дансанд өссөн буурсан асуудал байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь барилгын засварын болон бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд бичиг хэргийн 4,024.9 мянган төгрөгийн, аж ахуйн 49,646.1 мянган, барилгын засварын 2,929.0 мянган төгрөгийн, бусад хангамжийн 2,559.2 мянган, 71,832.3 мянган төгрөгийн мал амьтад байна



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 125,161.7 мянган төгрөгийн барилга байгууламж, 41307.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 395,826.1 мянган төгрөгийн зам гүүр, 55957.6 мянган төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйл, 516035.4 мянган төгрөгийн бусад хөрөнгө үнэ төлбөргүй шилжин ирж, төсвийн хөрөнгөөр 28,714.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 12,039.1 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 500.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, 932.2 мянган төгрөгийн санхүүгийн программ худалдан авснаар нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө өссөн нь 932,2 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамж худалдан авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн буурсан асуудал байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,982,514.0 мянган төгрөг болж 337,533.7 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгад тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 1,346,477.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,346,477.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,346,477.8 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Аймгийн Засаг даргын тамгын газраас замын өргөтгөлтэй холбоотойгоор айлын өмчлөлийн газар чөлөөлөхөд 4,620.0 мянган төгрөг, 11 дүгээр баг шинээр байгуулсантай холбоотой иргэдийн бичиг баримт, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ солих, багийн ажлын албанд тавилга эд хогшил, компьютер авахад 73,800.0 мянган төгрөг, шилдэг сумын шагналын 1,500.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс мал тооллогын 781.8 мянган төгрөг, Сумын орон нутгийн хөгжлийн сангаас улсын их баяр наадам зардал 5,000.0 мянган төгрөг, Тамгын газрын өөрийн орлогын 17,915.9 мянган төгрөг, нийт 103,617.7 мянган төгрөгийн нэмэлт төсөв бүрдүүлсэн байна.

Үүнээс бусад байгууллагаас ирсэн санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн зарцуулж, өөрийн орлогоос бий болсон эх үүсвэрээс цахилгаан дулаан хэрэглээний үнэ болон байр засварлах зардалд 12,000.0 мянган төгрөг, ажилтан албан хаагчдыг бичиг хэргийн зардалд 3,515.9 мянган төгрөгийг, хотын ногоон байгууламж өнгө үзэмж сэргээх зардалд 1,500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.



2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 21 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 127,286.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 39,771.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 13,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 64,783.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 9,731.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 77,783.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгөөр 13,000.0 мянган төгрөгийн шинэ жилийн бэлэг худалдан авч тараасан байна. Энэ нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-д хамаарахгүй, мөн Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэгт “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Хэрлэн сумын Засаг даргын захирамжаар Эмзэг бүлгийн өрхөд нүүрс, хүнсний материал олгоход 20,166.9 мянган төгрөг, ахмадын бүжгийн заалны түрээс, хөгжимчний хөлсөнд 10,799.4 сая төгрөг, төсвийн байгууллага, иргэдийн ном хэвлүүлэх дэмжлэгт 14,130.0 мянган төгрөг, туршлага судлахад 7,615.7 мянган төгрөг, хэрлэн голын тахилгад 1,071.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-д хамаарахгүй, мөн Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэгт “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тодруулга тайланд тусгагдсан аж ахуйн материалд түүвэрлэн биет горимыг хэрэгжүүлэхэд аж ахуйн материалд үндсэн хөрөнгийн шинж чанартай 3 нэр төрлийн 11,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна. Энэ нь санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 9,731.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.



2.13. Шилэн дансны мэдээлэл

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 132,5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Шатахууны данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд сумын Засаг дарга, Засаг даргын орлогч болон Тамгын газрын дарга нар албан тушаалын суудлын автомашин хэрэглэн 9,731.3 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Хөрөнгө арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|----------------------|----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 125282174,62 | 130991449,62 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 125282174,62 | 130991449,62 |
| 354 | Хангамжийн материал | 52803213,00 | 59159158,00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4564800,00 | 4024900,00 |
| 35420 | Аж ахуйн материал | 48238413,00 | 49646058,00 |
| 35450 | Барилгын засварын материал | 0,00 | 2929000,00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 0,00 | 2559200,00 |
| 35600 | Мал амьтад | 72478961,62 | 71832291,62 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 9519698110,05 | 9851522564,33 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 9519698110,05 | 9851522564,33 |
| 392 | Биет хөрөнгө | 9126737338,74 | 9489695478,68 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3231802767,30 | 3356964419,30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -209095671,76 | -282586481,30 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 201074113,00 | 201074113,00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -118715514,62 | -179798579,77 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 219766411,00 | 280382344,00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -116472514,55 | -147346108,81 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 186475665,93 | 195096270,33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -54318272,88 | -71053936,71 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 2490191333,00 | 2714523874,30 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -347291307,41 | -528861789,86 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1552052069,00 | 1608009669,00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2614240672,00 | 3135276092,00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -522972411,27 | -791984406,80 |
| 393 | Биет бус хөрөнгө | 392960771,31 | 361827085,65 |
| 39301 | Програм хангамж | 770000,00 | 1702200,00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -539424,75 | -825910,99 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 446343995,00 | 446343995,00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -53613798,94 | -85393198,36 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 9644980284,67 | 9982514013,95 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 9644980284,67 | 9982514013,95 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 9644980284,67 | 9982514013,95 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2217545201,36 | 2217545201,36 |
| 51101 | Өмч: - төрийн | 2217545201,36 | 2217545201,36 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 7350269910,77 | 7687803640,05 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7350269910,77 | 7350269910,77 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0,00 | 337533729,28 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 77165172,54 | 77165172,54 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 9644980284,67 | 9982514013,95 |



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1) | 2468602993,90 | 2614624803,20 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 751435042,00 | 1134288335,30 |
| 110 | Орлогын албан татвар | 751435042,00 | 1134288335,30 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 751435042,00 | 1134288335,30 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 751435042,00 | 1134288335,30 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5200000,00 | 37463420,00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5200000,00 | 37463420,00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 0,00 | 28942100,00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 0,00 | 28942100,00 |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/ | 5200000,00 | 8521320,00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1711967951,90 | 1442873047,90 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 319474051,90 | 103595247,90 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32000000,00 | 1500000,00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 256096450,00 | 10401808,00 |
| 131105 | төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд өий болсон нэмэлт | 31377601,90 | 91693439,90 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1392493900,00 | 1339277800,00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1392493900,00 | 1339277800,00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2207155263,24 | 2154981652,20 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2155176049,77 | 2154981652,20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2051853746,56 | 2114264994,88 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 552839999,99 | 640621785,23 |
| 210101 | Үндсэн цалин | 546839999,99 | 633924785,23 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0,00 | 697000,00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6000000,00 | 6000000,00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66340800,00 | 79752338,49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44227200,00 | 53988438,49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5327200,00 | 5153000,00 |
| 210203 | ҮОМЦЮ-ний даатгал | 4623900,00 | 6441400,00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1105700,00 | 1288500,00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11056800,00 | 12881000,00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 51869603,20 | 50237023,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19320827,20 | 14499774,00 |
| 210302 | Тулш, халаалт | 25455000,00 | 28715106,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7093776,00 | 7022143,00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 34401381,50 | 39046776,50 |
| 210401 | Бичиг хэрэг | 11169490,00 | 12278950,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10248150,00 | 12695000,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9230689,50 | 8365232,50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3513052,00 | 5707594,00 |
| 2105 | Нормативт зардал | 1239780,00 | 2533740,00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1239780,00 | 2533740,00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 33717432,54 | 69465780,00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 0,00 | 6500000,00 |
| 210604 | Урсгал засвар | 33717432,54 | 62965780,00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1409000,00 | 1809951,00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1409000,00 | 1809951,00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 140413634,00 | 7963280,00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 140413634,00 | 7783280,00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0,00 | 180000,00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1169622115,33 | 1222834320,66 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 642556845,00 | 495793692,36 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 527065270,33 | 727040628,30 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 103322303,21 | 40716657,32 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 19363997,00 | 28302031,90 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16871860,00 | 24185700,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2492137,00 | 4116331,90 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад блогох татаас, | 83958306,21 | 12414625,42 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 83958306,21 | 12414625,42 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 261447730,66 | 459643151,00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0,00 | 122109421,72 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0,00 | 122109421,72 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 0,00 | -122109421,72 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 261447730,66 | 337533729,28 |



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1717167951,90 | 1451394367,90 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5200000,00 | 8521320,00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5200000,00 | 8521320,00 |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/ | 5200000,00 | 8521320,00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1711967951,90 | 1442873047,90 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 319474051,90 | 103595247,90 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32000000,00 | 1500000,00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 256096450,00 | 10401808,00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 31377601,90 | 91693439,90 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1392493900,00 | 1339277800,00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1392493900,00 | 1339277800,00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1667332401,90 | 1451394367,90 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1667332401,90 | 1451394367,90 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1563010098,69 | 1410677710,58 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 552839999,99 | 640621785,23 |
| 210101 | Үндсэн цалин | 546839999,99 | 633924785,23 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0,00 | 697000,00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6000000,00 | 6000000,00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66340800,00 | 79752338,49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44227200,00 | 53988438,49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5327200,00 | 5153000,00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4623900,00 | 6441400,00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1105700,00 | 1288500,00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11056800,00 | 12881000,00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 52175603,20 | 50536037,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19320827,20 | 14499774,00 |
| 210302 | Түлш, халаалт | 25455000,00 | 28715106,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7399776,00 | 7321157,00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35820219,50 | 40637282,50 |
| 210401 | Бичиг хэрэг | 11365770,00 | 11464930,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10248150,00 | 12695000,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9230689,50 | 8365232,50 |
| 210404 | Ном, хэвлэл | 350000,00 | 185000,00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4625610,00 | 7927120,00 |
| 2105 | Нормативт зардал | 1971822,00 | 6048200,00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1971822,00 | 6048200,00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 56706835,00 | 79997614,00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0,00 | 6548000,00 |
| 210602 | Тавилга | 13645000,00 | 30174869,00 |
| 210604 | Урсгал засвар | 43061835,00 | 43274745,00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1409000,00 | 1809951,00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1409000,00 | 1809951,00 |



**Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

| | | | |
|-------------|---|---------------------|--------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 140463634,00 | 15477480,00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 140463634,00 | 7783280,00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0,00 | 180000,00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0,00 | 7514200,00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 655282185,00 | 495797022,36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 654969885,00 | 495797022,36 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 104322303,21 | 40716657,32 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 20363997,00 | 28302031,90 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16871860,00 | 24185700,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3492137,00 | 4116331,90 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 83958306,21 | 12414625,42 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 83958306,21 | 12414625,42 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 0,00 | 0,00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 0,00 | 0,00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0,00 | 0,00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| C01 | 2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2 217 545 201,36 | 77 165 172,54 | 7 350 269 910,77 | 9 644 980 284,67 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0,00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2 217 545 201,36 | 77 165 172,54 | 7 350 269 910,77 | 9 644 980 284,67 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0,00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0,00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0,00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0,00 |
| C08 | 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2 217 545 201,36 | 77 165 172,54 | 7 350 269 910,77 | 9 644 980 284,67 |
| D01 | 2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2 217 545 201,36 | 77 165 172,54 | 7 350 269 910,77 | 9 644 980 284,67 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2 217 545 201,36 | 77 165 172,54 | 7 350 269 910,77 | 9 644 980 284,67 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0,00 | 0,00 | 337 533 729,28 | 337 533 729,28 |
| D09 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2 217 545 201,36 | 77 165 172,54 | 7 687 803 640,05 | 9 982 514 013,95 |



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|---------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1346477800,00 | 1335384494,58 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1346477800,00 | 1335384494,58 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1314497100,00 | 1309698867,58 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 641095100,00 | 640621785,23 |
| 210101 | Үндсэн цалин | 634398100,00 | 633924785,23 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 697000,00 | 697000,00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6000000,00 | 6000000,00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 80138000,00 | 79752338,49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54494100,00 | 53988438,49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5129000,00 | 5153000,00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6411400,00 | 6441400,00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1282500,00 | 1288500,00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12821000,00 | 12881000,00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 47947400,00 | 47869783,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14499800,00 | 14499774,00 |
| 210302 | Түлш, халаалт | 25800000,00 | 27053426,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7647600,00 | 6316583,00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 39424400,00 | 39285272,50 |
| 210401 | Бичиг хэрэг | 10959600,00 | 10412920,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12699600,00 | 12695000,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8260400,00 | 8065232,50 |
| 210404 | Ном, хэвлэл | 330000,00 | 185000,00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7174800,00 | 7927120,00 |
| 2105 | Нормативт зардал | 6049200,00 | 6048200,00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6049200,00 | 6048200,00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 43815600,00 | 43779843,00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6583500,00 | 6548000,00 |
| 210602 | Тавилга | 13732100,00 | 13731969,00 |
| 210604 | Урсгал засвар | 23500000,00 | 23499874,00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1816500,00 | 1809951,00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1816500,00 | 1809951,00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10816900,00 | 10692480,00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 3121200,00 | 2998280,00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180000,00 | 180000,00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7515700,00 | 7514200,00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 443394000,00 | 439839214,36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 443394000,00 | 439839214,36 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 31980700,00 | 25685627,00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 31980700,00 | 25685627,00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30480700,00 | 24185700,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1500000,00 | 1499927,00 |

